



# МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

1993 оны I дүгээр  
сарын 29-ний өдөр

Дугаар 18

Улаанбаатар  
хст

ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний  
Комиссын дүрэм, бүрэлдэхүүнийг  
батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага - ЮНЕСКО -гийн Монголын Үндэсний комиссын дүрмийг энэ тогтоолын I дүгээр хавсралтаар, тус комиссын бүрэлдэхүүнийг 2 дугаар хавсралтын ёсоор тус тус баталсугай.

2. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "ЮНЕСКО-гийн Монголын Үндэсний комиссын дүрэм, бүрэлдэхүүнийг батлах тухай" Засгийн газрын 1991 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн 107 дугаар тогтоолыг хүчингүй болгоход тооцсугай.

Монгол Улсын Ерөнхий сайд

П. ЖАСРАЙ

Гадаад харилцааны сайд

Ц. ГОМБОСҮРЭН

УХАССО

Засгийн газрын 1933 оны 18 дугаар  
тогтоолын I дүгээр хэвсрэлт.

НЭГДСЭН ҮНДЭСНИЙ БАЙГУУЛЛАГЫН БОЛОВСРОЛ,  
ШИНЖЛЭХ УХААН, СОЁЛЫН БАЙГУУЛЛАГА-ЮНЕСКО-  
ГИЙН МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДҮРЭМ

НЭГ. Нийтлэг үндэслэл

1. ЮНЕСКО-гийн Монголын үндэсний комисс /цаашид комисс гэх нэрлэнэ/ нь ЮНЕСКО-гийн дүрмийн XII зүйл, ЮНЕСКО-гийн үндэсний комиссуудын дүрмийн дагуу Монгол улсын Засгийн газрын шийдвэрээр байгуулагдана.

2. Комиссын үндсэн зорилго нь үндэсний хууль тогтоомж, ЮНЕСКО-гийн дүрэм, олон улсын эрх зүйн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, хэм хэмжээг удирдлага болгон Монгол, ЮНЕСКО-гийн хамтын ажиллагааг хөгжүүлэх явдал мөн.

3. Комисс нь:

-Үйл ажиллагаандаа Монгол Улсын үндэсний эрх ашгийг өрхөмлөн, улс орны эдийн засаг, нийгмийн салбарт тавигдаж байгаа зорилтыг хэрэгжүүлэхэд нэмэр хандив оруулахыг чармайна;

-ЮНЕСКО-гийн үйл ажиллагаанд Монгол Улсын идэвхтэй оролцоог хангаж, боловсрол, шинжлэх ухаан, соёл, мэдээллийн салбарт ЮНЕСКО, түүний бүсийн төвүүд, үндэсний байгууллагатай хамтын ажиллагааг зохицуулна;

-Монгол орны түүх, соёлын өв, дурсгалт зүйл, байгалийн өвөрмөц тогтоц, үнэт ховор баялаг, нөөцийг хайрлан арвижуулах, нөхөн сэргээх талаар ЮНЕСКО, гишүүн орнуудтай нягт хамтран ажиллах чиглэлийг удирдлага болгоно;

-Монголын нууцлалын соёл иргэний, уламжлалт соёл, боловсрол, шинжлэх ухааны талаар гаднад ертөнцөд таниулах, эдгээр салбарын хөгжлийг хүн төрөлхтөний нийтлэг ололт амжилт, өөрийн орны өвөрмөц онцлогийг харгалзан урагшуулахад ЮНЕСКО, түүний системтэй тогтоосон хэлхээ холбоотой ашиглахыг чухалчилна;

## 2.

-Дэлхий нийтийн боловсрол, шинжлэх ухаан, соёл, мэдээллийг хөгжүүлэхэд чиглэсэн ЮНЕСКО-гийн бүхий л үйл ажиллагааг идэвхтэй дэмжин улс түмний ойлголцол, итгэлцлийг нэмэгдүүлэхэд тус дөхөм үзүүлнэ.

ХОЁР. Комиссын үүрэг, эрх

1. Үндэсний байгууллагуудаас ЮНЕСКО-гийн хүрээнд явуулах бодлого, үйл ажиллагааг уялдуулан зохицуулж, боловсрол, шинжлэх ухаан, соёл, мэдээллийн гадаад харилцааны гол чиглэлүүдийн нэгдлийг хангахад дөхөм үзүүлнэ.

2. ЮНЕСКО, түүний бүсийн төв, товчоо болон гишүүн орнуудын үндэсний комисс, байгууллагатай ажил хэргийн холбоо тогтоож хамтын ажиллагааг хөгжүүлнэ.

3. ЮНЕСКО-гийн төлөвлөгөө, хөтөлбөрүүдийг боловсруулах, хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар Монгол Улсын баримтлах бодлого, байр суурийн талаар санал, зөвлөмжийг нэгтгэн гаргах, ЮНЕСКО-той тохиролцоно.

4. ЮНЕСКО, түүний байгууллагуудтай байгуулсан хоёр болон олон талын хэлэлцээр, түүнчлэн хамтран гаргасан төлөвлөгөө, төсөл, бусад тохиролцооны дагуу Монгол Улсын хүлээсэн үүргийг биелүүлэх ажил зохион байгуулна.

5. Монгол Улсын нэгдэж орсон ЮНЕСКО-гийн холбогдох конвенц, зөвлөмжийг хэрэгжүүлэх талаар манай улсын хүлээсэн үүргийг биелүүлэх, түүнчлэн эрхийг хангахтай холбогдсон арга хэмжээ авч, биелэлтийн талаархи илтгэл тайланг ЮНЕСКО-д гарган өгч байна.

6. ЮНЕСКО-гийн шугамаар байгуулагдсан олон улсын болон бүсийн гэрээ, конвенц, эрх зүйн бусад баримт бичгийг судлан, эдгээрт Монгол Улс нэгдэж орохтой холбогдсон асуудлаар санал, зөвлөмж боловсруулж шийдвэрлүүлнэ.

## 3.

7. ЮНЕСКО болон түүний харьяа байгууллагуудын төлөөлөгч, хөтөлбөр, фонд зэргийг судлан ЮНЕСКО-гийн програмт арга хэмжээнүүдэд манай улс оролцохтой холбогдсон асуудлаар санал боловсруулах, ЮНЕСКО-гийн шугамаар зохиогдох буй хурал, семинар, курс, симпозиум зэрэгт өөрийн орны холбогдох байгууллагын төлөөлөгч, мэргэжилтнийг оролцуулах, түүнчлэн ийм хурал, зөвлөлгөөн, семинарыг өөрийн оронд зохион байгуулах ажлыг санаачлан хэрэгжүүлнэ.

8. ЮНЕСКО-гийн шугамаар тодорхой төслүүдийг хэрэгжүүлэх, санхүү, техник, эдийн засгийн тусламж авах боломжийг судалж үндэсний холбогдох байгууллагатай хамтран санал боловсруулах, хэрэгжүүлэх, шаардлагатай тайлан тооцоо, судалгаа, дүгнэлт, мэдээллийг ЮНЕСКО-д гаргаж өгөх ажлыг зохион байгуулна.

9. ЮНЕСКО-гийн зорилго, үйл ажиллагааны талаар Монголын олон нийтэд таниулан сурталчилж, ЮНЕСКО-г дэмжигчдийн клуб, нийгэмлэг, холбоо зэрэг үүсгэл санаачилгын байгууллагад зохих дэмжлэг үзүүлнэ.

10. Комисс нь ЮНЕСКО болон өөрийн үйл ажиллагааны талаар мэдээлэл нийтлүүлж болно.

11. Комисс шаардлагатай гэж үзвэл үйл ажиллагааныхаа хүрээнд ажлын хэсэг, комисс байгуулан ажилдуулж, холбогдох бусад байгууллагатай хамтран төсөл, төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлж болно.

12. Комисс нь үйл ажиллагаагаа тэтгэх үүднээс ЮНЕСКО-гийн зорилго, үүрэгт нийцсэн ажил, үйл ажиллагаа явуулж төсвийн гадуурхи эх үүсвэрээр өөрийн мэдлийн мөнгөн хөрөнгө, эд аж ахуйтай болж болно.

13. Комисс нь Гадаад харилцааны яамны холбогдох нэгжтэй хамтран ЮНЕСКО-гийн дэргэд суугаа Монгол Улсын Байнгын төлөөлөгчийн газрын ажлыг удирдан зааварлана.

4.

ГУРАВ. КОМИССЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

1. Комиссын бүрэлдэхүүнд холбогдох яам, газрын эрх мэдэл бүхий албан тушаалтан, боловсрол, шинжлэх ухаан, соёл, мэдээллийн салбарын нэр хүнд бүхий төлөөлөгчид орох бөгөөд комиссын бүрэлдэхүүнийг Монгол Улсын Засгийн газар батална.

2. Комиссын үйл ажиллагааг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлууд, ажлын тайлан, төлөвлөгөөг комиссын хурлаар хэлэлцэн шийдвэрлэж байна. Комиссын хурлыг жилд хоёроос дөвшгүй удаа хийнэ.

3. Гишүүдийн хурлын шийдвэрийг хэрэгжүүлэх ажлыг комиссын дарга, дэд дарга нар, хариуцлагатай нарийн бичгийн даргаас бүрдсэн тэргүүлэгчид удирдан зохион байгуулна.

Тэргүүлэгчдийн хурлыг шаардлагатай үед хийж комиссын ажлын төлөвлөгөөний биелэлт, холбогдох яам, газраас албан ёсоор ирүүлсэн санал, төсөл болон цаг үеийн бусад асуудлыг хэлэлцэж хамтын шийдвэр гаргана. Тэргүүлэгчдийн хуралд комиссын гишүүдийг болон шаардлагатай асуудлаар холбогдох байгууллагын төлөөлөгчдийг оролцуулна.

4. Комиссын өдөр тутмын ажлыг хариуцлагатай нарийн бичгийн дарга эрхлэн гүйцэтгэнэ.

Хариуцлагатай нарийн бичгийн дарга нь Тэргүүлэгчдийн удирдамж шийдвэрийн хүрээнд ЮНЕСКО болон гишүүн орнуудын үндэсний комисс, байгууллагуудтай харилцах, дотоод ажил хэргийг хөтлөн явуулах, түүнчлэн үндэсний комиссын хөрөнгийг Тэргүүлэгчдийн шийдвэрийн дагуу захиран зарцуулах, аж ахуй, санхүүгийн ажлыг хянан зохицуулах ажлыг хариуцна.

5. Комисс нь улсын төсөв, бусад эх үүсвэрээс санхүүжэнэ.

6. Комисс нь тогтоосон журмаар хийсэн албан бичгийн нүүр, тэмдэг хэрэглэнэ.

Засгийн газрын 1993 оны 18 дугаар  
тогтоолын 2 дугаар хавсралт

ЮНЕСКО-ГИЙН МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ КОМИССЫН  
БҮРЭЛДЭХҮҮН

Дарга  
Дэд дарга

Хариуцлагатай  
нарийн бичгийн  
дарга

Гишүүд:

- Гадаад харилцааны тэргүүн дэд сайд
- Шинжлэх ухаан, боловсролын тэргүүн дэд сайд;
- Соёлын тэргүүн дэд сайд.
- Үндэсний комиссын ажлын хэсгийн  
ажлагч
- ШУА-ийн дэд ерөнхийлөгч;
- Радио, телевизийн ерөнхий захирал;
- МОНЦАМЭ агентлагийн ерөнхий захирал;
- Гадаад харилцааны яамны Олон улсын бай-  
гууллагын хэлтсийн дарга;
- Шинжлэх ухаан, боловсролын яамны Шинжлэх  
ухаан, технологийн бодлогын газрын дарга;
- Шинжлэх ухаан, боловсролын яамны гадаад ха-  
рилцаа, хамтын ажиллагааны хэлтсийн дарга;
- Соёлын яамны Соёл, эдийн засгийн бодлогын  
газрын дарга;
- Соёлын яамны гадаадтай соёлоор харилцах  
хэлтсийн дарга;
- Байгаль, орчны яамны Шинжлэх ухаан, мониторинг,  
хамтын ажиллагааны газрын дарга;
- Геологи, эрдсийн баялгийн яамны Геологи, шин-  
жилгээний газрын ерөнхий захирал;
- Шинжлэх ухааны академийн түүхийн хүрээлэн-  
гийн захирал;
- Монголын соёлын оангийн даамал;
- Шинжлэх ухаан, техникийн мэдээллийн төвийн  
захирал;
- Улсын статистикийн газрын дарга;
- "Монгол хэрчэл" компанийн ерөнхий захирал;
- Хүүхдийн төлөө үндэсний төвийн дарга;
- Хот байгуулалтын хүрээлэнгийн захирал;
- ЮНЕСКО-гийн хөрөө, комюст сонгуультай  
хүмүүс, ЮНЕСКО-гийн шугамаар хэрэгжүүлж  
буй төслүүдийн Монголын талын ажлагч нар.